

## ТАНИЛЦУУЛГА

“Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай”  
Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан  
тухай

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 13.1.1, 13.1.2-т заасан үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсрууллаа.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн доод хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай” гэж заасан.

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 2023 оны 11 дүгээр сарын байдлаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 545.8 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 181.5 тэрбум төгрөг тус тус байна. Энэ 2 сангийн чөлөөт үлдэгдэлээс Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах боломжтой юм.

Энэхүү тогтоолын төсөлд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс санал авсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 98 дугаар тоот албан бичгээр уг тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжсэн тухай санал ирүүлсэн болно.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар улсын болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ